

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Татварын ерөнхий газрын даргын хамтарсан тушаал

2013 оны 02 дугаар
сарын 20 өдөр


Дугаар 1/84

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.4 дэх заалт, Засгийн Газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.9, 8.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Татварын ерөнхий газрын хооронд "Мэдээлэл харилцан солилцох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Мэдээлэл технологийн хэлтэс /Б.Эрдэнэ/, Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтэс /Ч.Эрдэнэбат/, Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар /Г.Батсайхан/, Мэдээлэл технологийн төв /Н.Нямдорж/-т тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэд дарга /М.Мөнхбат/, Татварын ерөнхий газрын дэд дарга /Ч.Жигжид/-д даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын 2006 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 49/106 тоот хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТУР ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАТМАГНАЙ

Татварын Ерөнхий газрын дарга, Гадаадын
иргэн, харьятын асуудал эрхлэх газрын даргын
хамтарсан 2013 оны 2 дугаар сарын **20**
өдрийн **18** дугаар тушаалын хавсралт



МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад албан болон хувийн хөргээр оршин суугаа гадаадын иргэн, харьялалгүй хүний татвар төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотой асуудлаар мэдээллээ тогтмол хугацаанд харилцан солилцох, шаардлагатай мэдээллээр цаг алдалгүй хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Татварын ерөнхий газар болон Гадаадын иргэн, харьятын асуудал эрхлэх газар /цаашид "Талууд" гэх/-ын хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Талууд мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагаандaa Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Татварын Ерөнхий хууль, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр солилцно.

1.4. Талууд нь үйл ажиллагааныхаа үр дүнг хагас жил тутам харилцан тайлagnана.

Хоёр. Талууд хоорондын хамтын ажиллагаа

2.1. Талууд бүртгэл, мэдээлийн үйл ажиллагаагаа боловсронгуй, хөнгөн шуурхай, чирэгдэлгүй болгох үйлчлүүлэгч буюу татвар төлөгчийн талаар олж авсан мэдээллийн нууцлалыг бүрэн хамгаалах, бусдад задруулахгүй байх зарчмыг удирдлага болгон ажиллана.

2.2. Талуудын бичгээр ирүүлсэн баримт мэдээллийг баталгаажуулах, мөн дотоодын хуулийг дагаж мөрдүүлэх болон хяналт шалгалт хийх, зөрчлийг шуурхай илрүүлэхэд нь туслах үүднээс харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллана.

2.3. Талууд ажлын онцлог, өөрсдийн нөхцөл бололцоонд тулгуурлан үйл ажиллагаандaa цаасгүй технологи ашиглах цаашид улам боловсронгуй болгон нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

Гурав. Солилцох мэдээллийн хамрах хүрээ, хэлбэр

3.1. Солилцох мэдээллийн хамрах хүрээ:

3.1.1. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын мэдээллийн

сангийн хувьд:

- Улс, муж /иргэний харъяалал/
- Овог
- Эцэг /эх/-ийн нэр
- Нэр
- Төрсөн огноо
- Хүйс
- Оршин суугаа хэлбэр
- Бүртгэсэн огноо
- Монгол Улсад зорчих виз /төрөл/
- Визийн зөвшөөрөл
- Уригч байгууллагын мэдээлэл /регистрийн дугаар, нэр, хаяг, утас/
- Эрх олгосон огноо
- Дуусгавар болох огноо
- Монгол Улсад оршин суух хаяг, утас
- Хаягийн өөрчлөлтийн мэдээлэл

3..1.2. Татварын Ерөнхий газрын мэдээллийн сангийн хувьд:

- Тодорхойлолтын дугаар
- Татвар төлөгчийн дугаар
- Татвар төлөгчийн нэр
- Хариуцлагын хэлбэр
- Хаяг, байршил
- Удирдлагын овог нэр, утас
- Татварын албан дүртгүүлсэн огноо
- Татвар төлөлт /Тодорхойлолт хамаарах оноор, татварын нэр төрлөөр/
- Татварын өртэй эсэх /Тодорхойлолт хамаарах оноор, татварын нэр төрлөөр/
- Тодорхойлолт үйлдсэн татварын газар, хэлтсийн нэр

Шаардлагатай тохиолдолд зарим мэдээлэлд нууцын хязгаарлалт тогтоож болно.

3.2. Мэдээлэл нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

3.2.1. Талуудын хүсэлтийн дагуу мэдээлэл солилцох

Энд талууд харилцан хүсэлт гаргаж мэдээлэл авах, өгөх үйл ажиллагаа хамаарна.

3.2.2. Байнгын хэлбэр

Энд энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд болон хувь хүний талаархи мэдээллийн санг харах эрхтэйгээр тогтмол албан ажлын хэрэгцээнд ашиглаж байх үйл ажиллагаа хамаарна.

3.2.3. Онцгой хэлбэр

Энд нэг тал нь хяналт шалгалт хийж байх үедээ нөгөө талд хэрэгтэй гэж үзсэн мэдээлэл олсон үед мэдэгдэх түүнчлэн шаардлагатай тохиолдолд анхааруулга болжон тусгай тэмдэглэл үйлдэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.

Дөрөв. Мэдээлэл харилцан солилцоход баримтлах дэг журам

4.1. Талууд мэдээлийн сангаас хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан зөвхөн харах эрхээр хандаж холбогдох мэдээллийг авна.

4.2. Мэдээллийг зөвхөн талуудын итгэмжлэгдсэн эрх бүхий албан хаагч авах бөгөөд нууцлалыг хангаж ажиллах талаар зохих арга хэмжээг авч ажиллана. Талууд санд байгаа холбогдох мэдээллийг зөвхөн албан ажлын хэрэгцээнд ашиглана.

4.3. Сүлжээний аюулгүй байдлыг талууд харилцан хамгаалж, хариуцан ажиллаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлсэн байна.

4.4. Санд буй цахим мэдээлэл болон цаасан суурьтай мэдээлэл хоорондоо зөрүүтэй байх тохиолдолд мэдээллийн үнэн зөвийг талуудын эрх бүхий албан тушаалтнууд шуурхай харилцан мэдээлж, асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

Тав. Бусад

5.1. Талууд шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулж болно.

5.2. Хоёр байгууллагын хоорондын хамтын ажиллагаанд бий болсон аливаа бэрхшээлтэй асуудлыг удирдлагын түвшинд хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3. Энэ журмыг зөрчин мэдээллийг хууль бусаар олж авсан болон хувийн ашиг сонирхлын үүднээс ашигласан, худал мэдээлэл өгсөн гэм буруутай төрийн албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

.....оо.....